

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/012/НА-СТА-ОНТС

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: С.Төмөрхуяг

Утас: 7058-4207, Цахим хаяг: tumurkhuyags@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-7
3. Аудитын илрүүлэлт	7
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	8

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СС	Сангийн сайдын
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV баир, Бага тойруу 3
Чингалтай дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976 51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/296
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН
САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
В.ЦЭНГЭЛМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,372,563.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны эцэст Сангийн яамнаас зарцуулах эрхийг зогсоосноос үүдэнгүйцэтгэгч байгууллагуудад шилжүүлэх гүйлгээ саатаж өглөг үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-13.Docx

1526140566

Сайн дурын үндсэн дээр хандив төвлөрүүлэх гэрээ байгуулсан газрын тос, уул уурхайн байгууллагууд тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй, алдагдалтай ажилласнаас орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөгөөнд тусгасан хандив тусламжийн орлого тасарч батлагдсан төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэл үүссэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. Наранчимэг* НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	860,496,112.91	658,826,975.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	860,496,112.91	658,826,975.41
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	860,496,112.91	658,826,975.41
31210	Төгрөг	860,496,112.91	658,826,975.41
31211	Төрийн сангийн харилцах	860,496,112.91	658,826,975.41
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	860,496,112.91	658,826,975.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	545,695,739.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	545,695,739.00
41300	Өглөг	0	545,695,739.00
41360	Бусад өглөг	0	545,695,739.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	545,695,739.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	860,496,112.91	113,131,236.41
51	Засгийн газрын хувь оролцоо	860,496,112.91	113,131,236.41
51200	Хуримтлагдсан үр дүн	860,496,112.91	113,131,236.41
51210	Өмнөх үеийн үр дүн	2,785,533,099.97	860,496,112.91
51220	Тайлант үеийн үр дүн	-1,925,036,987.06	-747,364,876.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	860,496,112.91	658,826,975.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,308,472,605.14	12,836,438,977.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,611,666,352.00	2,359,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,866,352.00	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,866,352.00	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,866,352.00	0
122	Тусламжийн орлого	2,599,800,000.00	2,359,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0	0
122002	Хандив тусламж /гадаад/	2,599,800,000.00	2,359,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,696,806,253.14	10,477,438,977.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	8,696,806,253.14	10,477,438,977.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0	3,003,282,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	8,696,806,253.14	7,474,156,877.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	11,308,472,605.14	12,836,438,977.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,233,509,592.20	13,583,803,854.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	13,233,509,592.20	13,583,803,854.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,925,036,987.06	-747,364,876.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	11,308,472,605.14	12,836,438,977.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,611,666,352.00	2,359,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,866,352.00	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,866,352.00	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,866,352.00	0
122	Тусламжийн орлого	2,599,800,000.00	2,359,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0	0
122002	Хандив тусламж /гадаад/	2,599,800,000.00	2,359,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,696,806,253.14	10,477,438,977.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	8,696,806,253.14	10,477,438,977.50
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0	3,003,282,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	8,696,806,253.14	7,474,156,877.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	11,308,472,605.14	12,836,438,977.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,233,509,592.20	13,038,108,115.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,233,509,592.20	13,038,108,115.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,233,509,592.20	13,038,108,115.00
223001	Бусад хөрөнгө	13,233,509,592.20	13,038,108,115.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-13,233,509,592.20	-13,038,108,115.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,925,036,987.06	-201,669,137.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,785,533,099.97	860,496,112.91
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	860,496,112.91	658,826,975.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	2,785,533,099.97	2,785,533,099.97
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	2,785,533,099.97	2,785,533,099.97
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-1,925,036,987.06	-1,925,036,987.06
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	860,496,112.91	860,496,112.91
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	860,496,112.91	860,496,112.91
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	860,496,112.91	860,496,112.91
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-747,364,876.50	-747,364,876.50
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	113,131,236.41	113,131,236.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,105,960,300.00	13,038,108,115.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,105,960,300.00	13,038,108,115.00
223001	Бусад хөрөнгө	15,105,960,300.00	13,038,108,115.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,105,960,300.00	13,696,934,977.50
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,696,464,300.00	10,477,438,977.50
320001	Орон нутгийн төсвөөс	3,003,282,100.00	3,003,282,100.00
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	7,693,182,200.00	7,474,156,877.50
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	3,549,000,000.00	2,359,000,000.00
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	3,549,000,000.00	2,359,000,000.00
4	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	860,496,000.00	860,496,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	860,496,112.91
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	658,826,975.41

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,372,563.5 мянган төгрөгийн зөрчилд¹ 2 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 3,372,563.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Батлагдсан төсөв, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Сайн дурын үндсэн дээр хандив төвлөрүүлэх гэрээ байгуулсан газрын тос, уул уурхайн байгууллагууд тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй, ашигтай ажиллаагүй гэх шалтгаанаас орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх ОНХС-ийн орлогын төлөвлөгөөнд тусгасан хандив тусламжийн орлого 1,190,000.0 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.2.2-т “Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ” гэж заасны 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогыг бодитой төлөвлөж, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт 2: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тайлант онд нийт 80 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2,182,563.5 мянган төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.” гэсэн заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг хангаж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	2	3,372,563.5	-	-	-	-	2	3,372,563.5
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	2	3,372,563.5	-	-	-	-	2	3,372,563.5